



ГОВЬСУМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 1169

Шивээговь сум

Ажлын гүйцэтгэлийг хүлээж авах  
комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 271 дүгээр “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам батлах тухай” тогтоол, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.12 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Говьсүмбэр аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 2023-22/02-10 дугаар улсын байцаагчийн албан шаардлагын дагуу сумын 2021 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хэрэгжих “Боржигин өв соёлын танхимтай болох үзмэрийг баяжуулах” ажлын дутуу хийгдсэн ажлыг бүрэн гүйцэд гүйцэтгүүлж, хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга:

Д.Отгонжаргал

(Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд:

Б.Алтансүх

(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Г.Гансулд

(Соёлын төвийн даргын үүргийг түр  
орлон гүйцэтгэгч)

Ш.Буяннэмэх

(2-р багийн иргэн)

Нарийн бичгийн дарга:

Д.Баттуул

(Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдаа авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Боржигин өв соёлын үзмэр бусад дагалдах хэрэгслийг соёлын төвийн хөрөнгөд бүртгэж, ашиглалт хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг байгууллагын дарга (Г.Гансүлд)-д үүрэг болгосугай.

3. Гүйцэтгэлийн ажлыг захиалагчаас гаргасан ажлын даалгаврын дагуу шаардлагад нийцсэн ажлыг хүлээн авч, акт үйлдэн холбогдох баримтыг хавсарган хүлээлцэхийг комиссын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ч.СУГАРМАА

